

**ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭМЖЭЭ ХЯЗГААР,
ТҮҮНИЙГ ХЭТРҮҮЛСЭН ТУХАЙД ХҮЛЭЭЛГЭХ
ХАРИУЦЛАГА**

Б.Хишигтогтох

ХСИС-ийн Цагдаагийн Сургуулийн МАОТТ-ийн
ахлах багш, докторант цагдаагийн дэд хурандаа

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч бусад нөхцөл байдлуудын нэгэн адил хуульд урьдчилан тодорхойлж заасан үндэслэл, шалгуур хэр хэмжээний дотор болсон тохиолдолд уг үйл явдлыг хууль ёсны үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд харин тэдгээрийг зөрчсөн тохиолдолд тэрхүү үйл ажиллагааных нь нийгмийн хор аюулынх нь мөн чанараас шалтгаалж эрүүгийн буюу захиргааны хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй юм.

Гэвч бидний судалгааны ажлын гол зорилго нь захиргааны хариуцлагын тухай асуудлыг биш чухамхүү эрүүгийн эрх зүйн үр дагаврыг нь судлан тодорхойлох явдал болно.

Ер нь хууль ёсны эрх хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэхэд хүргэсэн тодорхой нөхцөл байдал нь ямагт бодитой, тийм үйл ажиллагаа хийхэд зайлшгүй хүргэсэн нөхцөлтэй байх бөгөөд чухамхүү тэр үндэслэл, нэг үгээр хэлбэл хэр хэмжээг хэтрүүлсэнийг нарийвчлан тогтоосон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зайлшгүй бөгөөд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь дураараа авирласан, эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан шинжтэй байж болохгүй.

Хэрвээ тийм үндэслэл байвал уг үйлдэл буюу үйл ажиллагаа нь эрүүгийн хуульд заасан, биеэ даасан гэмт хэрэг болох нь тодорхой. Өмнөх бүлгүүдэд бид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үндэслэл, шалгуур, хэр хэмжээг тодорхойлон авч үзсэн учир энд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хэр хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд нэн ялангуяа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг өөр бусад төсөөтэй нөхцөл байдлуудаас ялган зааглах буюу эрүүгийн эрх зүйн мэргэжлийн томъёоллоор тухайн болсон үйл явдлыг зүйлчлэх хууль цааз эрүүгийн эрх зүйн асуудлыг голлон авч үзэхийг эрмэлзэв. Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хэр хэмжээ, үндэслэл, шалгуурыг дахин нэгтгэж товч тодорхойлвол:

1. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны зохицуулалтын эх сурвалжийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бие даасан бусад салбар хуульд урьдчилан тодорхойлж зааж өгсөн байдаг.
2. Эдгээр зохицуулалт нь заавал хууль буюу холбогдох эрх зүйн актаар албан ёсоор батлагдсан байдаг тул хэрэгжилт зохицуулалт нь бодитой, гарцаагүй биелүүлэх шинжтэй байдаг.
3. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь хуулинд тодорхойлон заасан хэлбэр, журмын дагуу байх ёстой.
4. Уг үйл ажиллагаа нь хэдүйбээр бодитой хор хохирол учруулдаг ч гэсэн зорилго, мөн чанарын хувьд нийгэмд ашигтай байдаг.
5. Тухайн болж буй үйл явдал нь зайлшгүй шинжтэй байдаг.
6. Уг үйл ажиллагаа нь алба, мэргэжил, үүргийн хувьд заавал хийх ёстой үйлдэл байдаг зэрэг үндэслэлүүдийг тодорхойлж байна.

Иймд дээр дурьдсан үндэслэл, шалгуур, хэр хэмжээг хэтрүүлсэн үйл ажиллагаа нь хэдүйбээр хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа боловч гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал бус харин нийгэмд аюултай гэмт хэрэгт тооцогдох нь тодорхой.

Гэвч хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа болон түүнийг зохицуулж буй эрх зүйн акт нь маш олон төрөлтэй байдаг тул уг үйлдлийн явцад бусдад хор хохирол учирсан үйл ажиллагаа нь мөн янз бүр байдаг болох нь нэн ойлгомжтой боловч уг тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг эрүүгийн эрх зүйн бус өөр холбогдох эрх зүйн актуудыг зайлшгүй харгалзахад хүргэдэг боловч ерөнхий суурь үндэслэл нь эрүүгийн хуулийн хэм хэмжээ байх ёстой гэж үзэж байна.

Чухам энэ тухай Н.Т.Иванов бичихдээ: «Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь хэдүйбээр янз бүр байх боловч тэдгээрийг зохицуулах гол эх сурвалж болсон хэм хэмжээг эрүүгийн хуулинд тусгаж өгөхдөө дараахь онцлогийг харгалзан үзвэл зохистой. Үүнд:

1. Тухайн этгээд (ажилтан) аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал болон гэмт хэрэг үйлдэж байгаа хүнийг баривчлан саатуулах зэрэг нөхцөл байдлын улмаас өөрийнхөө хийж буй үйлдлийн мөн чанарыг тухайн үедээ бүрэн ухамсарлаагүйгээр үл барам өөрийнхөө хийж буй үйл ажиллагаа нь хууль зөрчиж байгаа буюу алдаа гаргаж байна гэдгээ үнэхээр мэдэх боломжгүй нөхцөл байдалд уг үйлдлийг хийсэн эсэхийг нарийвчлан тогтоох;
2. Тухайн этгээд (ажилтан) уг бодит нөхцөл байдлын үед уг хийж байгаа үйл ажиллагааныхаа нөхцөл байдлын мөн чанарыг бүрэн таниж мэдэх ёстой буюу тийнхүү ойлгож ухаарах боломжтой нөхцөлд тухайн үйл ажиллагаа нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэл гэдгээ мэдэхгүйгээр бусдад хор хохирол учирсан байвал тэр нь гэм буруугүй болгоомжгүй хэлбэртэй үйл ажиллагаа болно гэдгийг тодорхойлон тогтоох зохих үндэслэл, шалгуурыг зааж өгөх;
3. Тухайн нөхцөл байдлыг буруугаар (андуурч) танин мэдсэний улмаас тодруулбал гэмт этгээдийн довтолгооны мөн чанарыг андуурч төсөөлсний улмаас түүний (ажилтны) хийсэн үйл ажиллагаа нь аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэн байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн нөхцөл байдлуудыг эрүүгийн хуульд бодитой тусган оруулах шаардлагатай юм¹» гэжээ. Энэ нь хэдүйбээр тухайн нөхцөлд гарч болох «үл мэдэгдэх» гэж хэлж болохуйц нөхцөл байдлуудын талаар тайлбарлаж байгаа тул хууль ёсны зарчимтай төдийлөн нийцэхгүй байж болох талтай боловч ийм нөхцөл байдлуудыг хууль тогтоогч холбогдох хууль буюу эрүүгийн хуулинд албан ёсоор тусгаж оруулж өгснөөр эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний хүчин чадлыг олох учиртай.

Ер нь эрүүгийн эрх зүйн онол-арга зүйн үүднээс авч үзвэл аргагүй хамгаалалтын төрөлд гэм буруугийн андуурлын улмаас хийсэн “хуурамч хамгаалалт”-ын тухай асуудлыг судлаачид аль эрт хөндөн тавьсан билээ. Ийнхүү аргагүй хамгаалалтын үндэслэл, хэр хэмжээ, шалгуурыг хэдий чинээ шинжлэх ухааны үндэстэй нарийвчлан тайлбарлавал төдий чинээ олон нийтэд нөлөөлөх юуны өмнө ёс зүйн хүмүүжлийн нийгэмд ашигтай чиг хандлагыг төлөвшүүлэхэд ач холбогдолтой.

Энэ чиглэлээр Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид нилээд бодит ач холбогдолтой өөрчлөлтийг хийсэн. Тодруулбал 2002 оны эрүүгийн хуулийг шинэчлэхдээ аргагүй хамгаалалтын ерөнхий ойлголт, цар хүрээг өмнөх эрүүгийн хуулиас арай нарийвчилж, чухамхүү олон нийтийн ёс зүйг харгалзан үзсэний үндсэн дээр “аргагүй хамгаалалтыг хэтрүүлэх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг эрүүгийн хуулиас хассан билээ.

Дээр дурьдснаас үндэслэж аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал болон гэмт хэрэгтнийг баривчлан саатуулж байгаа үйлдлийг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанаас ялгахын тулд дараахь тайлбар-томъёоллыг тодорхойлохыг эрмэлзэв. Тухайлбал “Тухайн этгээд (ажилтан) өөрийнхөө хийж байгаа үйл ажиллагааг буруу болохыг ухамсарлаагүй, тухайн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан нэн ялангуяа учирч болох хор уршгийг мэдээгүй, мэдэх ёсгүй байсны улмаас хийж байгаа зүйлээ хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байна гэж үзсний улмаас хэрэгжүүлсэн үйлдэл нь мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа болно” гэж үзэж байна.

Гэвч энэ нь мөн чанарын хувьд гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй үйлдсэн гэмт хэрэгт тооцогдож болох талтай гэдгийг цаашид анхаарч судлууштай бөгөөд практикт гарсан иймэрхүү нилээд тохиолдлыг шүүх мөрдөн байцаалтын практикт болгоомжгүй гэмт хэрэгт тооцсон байдаг.

Ийнхүү “Тухайн ажилтан өөрийнхөө хийж байгаа ажлын мөн чанарыг ухамсарлаагүй, ухамсарлах боломжгүй байсан, учирч болох хор уршгийг мэдээгүй, мэдэх ёсгүй байсан” нөхцөл (шинж) нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны нэг үндсэн шинж байж болох талтай боловч энэ нь “гэм буруугүйгээр хохирол, хор уршиг учруулах” үйлдэлтэй нэн төсөөтэй. Гэвч бидний үзэж буйгаар уг тохиолдлын субъект нь энгийн хүн биш харин чухамхүү тусгай эрх, үүрэг хүлээсэн юуны өмнө цагдаагийн ажилтан байдгаараа ялгаатай.

¹ И.Т. Иванов. Н.Г. Модельный уголовный курс. Общая часть / Н.Г. Иванов, -М, 2003, 90-9№-р тал

Яагаад гэвэл ийм төсөөтэй тохиолдолд жирийн иргэн буюу «энгийн хүн» хийсэн үйл ажиллагаа нь гол төлөв санамсаргүй тохиолдлын улмаас хийсэн үйлдэл, тодруулбал уг үйл ажиллагаа нь тусгайлан хүлээсэн үүрэг буюу албаны үйл ажиллагаатай холбоогүй байдгаараа онцлогтой тул дээр дурьдсан шинж бүхий үйл ажиллагаа хийсэн цагдаагийн ажилтны үйлдлийг гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй гэмт хэрэгт тооцож болох талтай. Гэвч энэ нь ямагт хөнгөрүүлэн үзэх үндэслэлтэй байдаг учир хэрэв нарийвчлан тогтоовол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл ч болж болох талтай. Үүнтэй холбогдуулж ОХУ-ын судлаач–эрдэмтэн В.А.Владиморов, Ю.И.Лепунов нарын бичсэн номонд дурьдсан нэгэн жишээг авч үзье.

“Нэгэн шөнө үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн ажилтан түүний зохих шаардлагыг биелүүлээгүй давхиж өнгөрсөн тээврийн хэрэгслийг зогсоохоор араас нь нэхэж явтал тэрхүү зугтсан авто машины бүхээгт гал манас хийсэнд уг авто машины жолоочийг галт зэвсэг хэрэглэв гэж бодсон цагдаагийн ажилтан өөртөө авч явсан албаны буугаа гаргаж хариу буудсан боловч оноогүйгээр үл барам ямар нэгэн хор хохирол учруулсангүй байна.

Гэтэл үнэн хэрэгтээ зугтааж явсан машины жолооч асаагуураар тамхиа асаасныг бууны гал гарлаа гэж эндүүрснээр уг үйл явдал болжээ”². Энэ тохиолдлыг хууль ёсны үүргээ хэрэгжүүлсний улмаас үйлдсэн гэм буруугийн болгоомжгүйн хэлбэртэй гэмт хэрэг гэж үзсэн бөгөөд тухайлбал цагдаагийн ажилтан тухайн үед хийж байгаа үйл ажиллагааныхаа мөн чанарыг ухамсарлаагүй, ухамсарлах боломжгүй байсан. Улмаар учирч болох хохирол хор уршгийг мэдээгүй, мэдэх ёсгүй байсан бодит шинж бүхий үйл ажиллагаа гэж тооцжээ.

Ийнхүү хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдал болох нэг бодит үндсэн шинж-нөхцлийг товчхон тайлбарлав. Одоо хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үйл ажиллагааны нөхцөл байдалд тооцогддог бас нэг өөр бие даасан нөхцөл байдлын үндэслэл нөхцлийг арай дэлгэрүүлэн авч үзье.

Тухайлбал эхнэр, нөхөр болон ойрын төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах нь мөн чанарын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан эх сурвалж бүхий хууль ёсны үйл ажиллагаа мөн гэдгийг дээр нэгэнтээ дурьдсан боловч аливаа хүн «худал мэдүүлэг гаргах эрх»-гүй бөгөөд хэдүйбээр гэр бүлийн ба ойрын төрөл садны холбоотой ч гэсэн тухайн болсон хэргийн талаар худал мэдүүлэх, гэрчлэхийг хуулиар хориглосон бөгөөд бусдыг зориуд санаатайгаар гүтгэсэн байвал эрүүгийн хариуцлага хүлээх нь тодорхой. Гэвч ийм нөхцөл байдал онцгой тохиолдолд гарсан байвал уг үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцох үндэслэлтэй байж болох талаар судлаачид нилээд янз бүрийн санал-дүгнэлт дэвшүүлж байна. Жишээлбэл: Энэ тухай В.А.Блинников бичихдээ: “Гэмт хэргийг үгүйсгэж байгаа нөхцөл байдлууд нь өөр хоорондоо харилцан холбоотой тэрч байтугай яг адилхан нөхцөл байдлууд нэгэн зэрэг гарах тохиолдол байж болохыг эрүүгийн эрх зүйн онол арга зүй хүлээн зөвшөөрдөг, улмаар яг нэг ижил үйлдэл нэгэн зэрэг гарах тохиолдол ч байдгийг үгүйсгэхгүй.

Харин уг болсон үйл явдлуудыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхдээ тухайн этгээдийн (адилхан үйлдэл хийсэн) эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр шийдвэрлэх учиртай” гэжээ.³ Үүнийг дээр дурьдсантай холбож тайлбарлавал эхнэр, нөхөр хоёр тухайн үед болсон нэг адилхан нөхцөл байдлыг яг ижилхэн тохиолдолд үзэж харсан байвч харилцан адилгүй өөр өөр байдлаар мэдүүлэх явдал гарч болно.

Гэвч уг асуудлыг шийдвэрлэхдээ аль алиных нь эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр тэгш хандаж байх хууль ёсны тэгэхлээр эрх зүйн үндэслэлийг тодорхойлсон хэрэг. Товчхон хэлэхэд аливаа асуудалд ялангуяа түүнийг шийдвэрлэхэд ямарваа нэг эргэлзээ гардаг нь зайлшгүй зүйл бөгөөд харин түүнийг шийдвэрлэхдээ тухайн хүний эрх зүйн байдлыг дордуулахгүй байх гэдэг бодит зарчмын гол эх сурвалж нь Үндсэн хуулийн заалт байдаг болох нь нэн тодорхой.

Гэмт хэргийг үгүйсгэж байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ түүнийг үйлдсэн хүн гэмт хэргийн субъект болох эсэхээс үл шалтгаалж болсон үйл явдлын мөн чанар, үндэслэл, шалгуурыг бүрэн дүүрэн, бодитой тодорхойлон тогтоох нь уг асуудалд хандах хууль эрх зүйн гол зарчим, байх ёстой гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй юм.

² Ляпунов, Ю.И. Общественно опасность деяния как универсальная категория советского уголовного права /Ю.И. Ляпунов, -М, 1989, 91-рг тал

³ В.А.Блинников, В.А. Обстоятельства, исключающие преступность деяния, в уголовном праве России (В.А.Блинников, -Ставрополь, 2001, 48-р тал)

Цагдаагийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхдаа галт зэвсэг хэрэглэсний улмаас бусдад гэм хор учруулсан асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарвал зохих үндсэн гурван нөхцөл байдал байна. Тухайлбал:

- а) Уг үйл явдал нь аргагүй хамгаалалтын
- б) Гарцаагүй байдлын
- в) Гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийг саатуулах буюу баривчилж байгаа ажиллагааны шинжгүй байх учиртайг онцгой нарийвчлан тогтоох шаардлагатай бөгөөд хэрвээ дурьдсан шинжүүд байвал уг болсон үйл явдал нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаанд тооцогдохгүй байж болох талтай.

Энэ үндэслэлийн тухай Э.Ф.Побегайло, В.П.Ревин нар бичихдээ: «Цагдаагийн ажилтан галт зэвсэг хэрэглэсэн үйл ажиллагааг шийдвэрлэн тогтоохдоо уг болсон үйл явдал нь аргагүй хамгаалалтын шинжтэй болсон эсэхийг маш нарийн зааглан тогтоох шаардлагатай бөгөөд тэрхүү галт зэвсэг хэрэглэсэн үйлдэл нь аргагүй хамгаалалтын дагнасан шинжгүй байх учиртай.

Хэрвээ аргагүй хамгаалалтын улмаас галт зэвсэг хэрэглэсэн байвал тэр нь бие даасан гэмт хэрэг болно. Харин ажилтан галт зэвсэг хэрэглэсэн нь чухамхүү цагдаагийн алба үүрэгтэй нь шууд холбоотой байвал хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд тооцогдох гол үндэслэл шалгуур нь болох ёстой” гэжээ.⁴

Ер нь аливаа хүн өөрийгөө хамгаалах бодитой үйл ажиллагаа хийх нь нэн түрүүнд хүн бүрийн ёс зүйн үүрэг болдог бөгөөд энэ нь уг үйл явдлын амин буюу социал шинж төдийгүй холбогдох хуульд баталгаажуулж өгсөн бодит шинж юм.

Чухам энэ үндэслэлийг Монгол Улсын “Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 4.1-д заахдаа “хүн, мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай халдлагаас зайлсхийх, эсвэл бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхийг үл харгалзан аргагүй хамгаалалт хэрэглэх эрхтэй” гэж заасан төдийгүй улмаар 4.4-д “хууль сахиулагч, харуул хамгаалалтын албан хаагч албан үүргээ гүйцэтгэх хууль зүйн дагуу хийсэн үйлдлийх нь эсрэг хийсэн хариу үйлдлийг өөрийгөө хамгаалсан гэж үзэхгүй” гэж тодорхойлсон нь зохих үндэслэл шалгуурын дотор болсон үйл ажиллагаа нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа буюу гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдал болох хууль-эрх зүйн бодит орчинг нэгэнтээ нээж өгсөн заалт болжээ.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны гурав дахь нэг гол үндэслэл буюу бие даасан шинж нь холбогдох хуульд түүний зөвшөөрсөн хэлбэрийг заасан явдал юм. Хэрвээ уг үндэслэл шалгуурыг зөрчсөн үйл ажиллагаа болбол уг үйлдлийг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэлд тооцохгүй тул тэр нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэл биш төдийгүй харин тодорхой бодит зөрчилд улмаар гэмт хэрэгт тооцогдоно. Харин иймэрхүү үйл явдлыг зохицуулах тодорхой хэм хэмжээ Монгол Улсын холбогдох хуульд одоогоор байхгүй байна.

Тэгвэл ОХУ-ын эрүүгийн хуульд тухайлбал 330-р зүйлд нь “Дураараа авирлах” (самоуправство) гэж томъёолж болохуйц гэмт хэргийн бие даасан бүрэлдэхүүнийг тодорхойлон заажээ. Энэ төрлийн гэмт хэргийн объект нь гол төлөв нийгмийн харилцаа буюу түүнийг зохицуулах хууль ёсны эрх үүрэгтэй холбогдуулан тогтоосон тодорхой дэг журам байдаг бол объектив тал нь хууль буюу эрх зүйн бусад актаар тогтоосон дэг журмыг зөрчсөний улмаас бусдад хор хохирол учруулсан идэвхитэй үйл ажиллагаа, субъект нь тэрхүү хэв журмыг сахиулах үүрэг хүлээсэн байгууллага (олон нийтийн) буюу тодорхой хувь этгээд буюу иргэн байдаг.

Товчхон хэлэхэд өөртөө олгогдсон эрхээ хууль бусаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм. Ийм нөхцөл байдлын улмаас хохирол хүлээсэн этгээд түүнийгээ нөхөн сэргээлгэх эрхтэй болох нь тодорхой бөгөөд ийм шинж бүхий бодит үйл ажиллагаанд (дураараа авирлах) эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Чухам ийм үйл явдлын тодорхой жишээг А.Р.Саруханян тайлбарлан бичжээ. Үүнд: “хэн нэг этгээд аль нэгэн хүний буюу бусдын эд хөрөнгийг устгасан буюу гэмтээсэн тохиолдолд хуульд заасан журмын дагуу учирсан хохирлыг сэргээлгэх буюу нөхөн төлүүлэх эрхтэй байдаг.

Энэ нь амьдрал-практикт гол төлөв дураараа авирласан үйл ажиллагаатай холбогдож гардаг. Жишээлбэл: Иргэн “К” өөрийн хөрш иргэн “У”-ийн систем хөгжмийг 2 өдрийн хугацаатай авч төрсөн өдрөө тэмдэглэжээ. 5 хоногийн дараа “К”-тай таарч хөгжмөө нэхсэнд “тэр чинь

⁴ Э.Фобегайло, Правомерность действий сотрудников внутренних дел и граждан при необходимости, обороне и задержаний преступника (Э.Ф. Побегайло, В.П.Ревин-Брянск, 1988,54-р тал)

эвдэрчихсэн” гэж хэлсэн байна. Түүний дараа “К” удаа дараа элдэв арга саам хэлсээр хэдэн өдөр өнгөрсөнд “У” нь “К”-нд орж “Sony” маркын телевизорыг нь авчээ улмаар энэ нь хохирлоо нөхөн төлүүлэх талаар хуульд тогтоосон журмыг зөрчсөн үйл ажиллагаа буюу “дураараа авирласан” гэмт хэрэг үйлдсэнд тооцогдож эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүрсэн байна. Зүй нь иргэн “У” хуульд заасан журмын дагуу хохирлоо барагдуулсан бол тэр нь гэмт хэрэг биш чухамхүү хууль ёсны эрхээ хэрэгжүүлсэн явдал болох байв”⁵ гэжээ.

Хэрвээ ийм тохиолдол манайд (Монголд) гарсан бол уг асуудлыг юуны өмнө Монгол Улсын Иргэний хуулийн 9.4.9, 12-р зүйлд заасан журмаар тодруулбал иргэний эрхийг хамгаалах үндсэн журмын дагуу буюу “өөртөө туслах” замаар тухайн учруулсан гэм хорыг арилгах нь лавтай. Өөрөөр хэлбэл уг болсон асуудлыг иргэний журмаар шийдвэрлэхэд хүрнэ. Гэтэл уг асуудлыг гэмт хэргийн шинжтэй болбол түүнийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус байгаа тул уг асуудалд зохих чиглэлийн судлаач-эрдэмтэд анхаарах цаг нэгэнтээ болоод байгааг энэ дашрамд тэмдэглэж байна.

Ийнхүү хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцох бусад нилээд олон төрөл үйлдэл байдаг болохыг гол төлөв ОХУ-ын хууль тогтоомж, мөн мөрдөн байцаалт, шүүхийн практик ажиллагаануудын жишээн дээр тайлбарлахыг оролдсоны дээр тэдгээрээс санаа авч манай Монгол Улсын холбогдох хууль нэн ялангуяа эрүүгийн хууль тогтоомжуудад тусган оруулж болохуйц үндэслэлүүдийн талаар харьцангуй бие даасан санал дүгнэлтийг тайлбарлав. Цаашилбал хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны бие даасан төрөлд багтаж болох өөр хоёр үндсэн нөхцөл байдлуудыг товч томъёолон дурдвал:

а) Эхнэр, нөхөр болон ойрын төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзаж буй үйлдэл нь мөн чанарын хувьд холбогдох хууль эрх зүйн эх сурвалжтай үйлдэл байдаг бөгөөд энэ нь гадаадын зарим орны хувьд онцолбол ОХУ-ын эрүүгийн хуульд “дуугүй байх эрх” гэсэн томъёолол бүхий бие даасан зүйл байдаг болох талаар өмнөх бүлэгт товч дурьдсан.

б) Бодитой аюул эрсдлээс (гал түймэр, газар хөдлөлт гэх мэт) аврах янз бүрийн үйл ажиллагааны үед гол төлөв тусгай албаны хүмүүсийн мэргэжил, алба-үүргийн гүйцэтгэж байгаа төрөл бүрийн ажиллагаа нь мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа нөхцөл байдалд тооцогдох бодит үндэслэлтэй байдаг. Гэвч энэхүү дурьдаж буй үндсэн хоёр нөхцөл байдал нь миний судалгааны ажлын гол сэдэв-зорилго биш тул хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь цагдаагийн албаны үүрэгтэй хэрхэн холбогдох асуудлыг дагнан авч үзсэн болно. Нөгөө талаар хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдал болохын хувьд ямагт хөнгөрүүлэх нөхцөл-үндэслэл болох нь лавтай бөгөөд харин уг асуудлыг эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол-арга зүйн үүднээс нарийвчлан судалж хууль ёсны үндэслэл, хэр хэмжээ шалгуурыг нь бодитой тодорхойлон тогтоож юуны өмнө гэмт хэргийн тухай болон цагдаагийн албаны тухай хууль, бусад холбогдох хуульд нэн даруй тусган оруулах шаардлагатай байна.

Эцэст нь дээр дурьдсан бүх зүйл асуудлыг нэгтгэж дараахь санал дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэж байгаа бусад нөхцөл байдлуудын нэгэн адил холбогдох хуульд тодорхойлон заасан үндэслэл, хэр хэмжээ, шалгууртай байх ёстой бөгөөд гагцхүү түүнийг нарийвчлан тогтоосны үр дүнд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогдох ёстой. Харин тэдгээрийг хэтрүүлсэн товчоор хэлэхэд зөрчсөн тохиолдолд уг болсон үйл явдлын нийгмийн хор аюулынх нь мөн чанарыг харгалзан үзэж захиргааны буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх;
2. Хэрвээ тухайн этгээд (цагдаагийн ажилтан) хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдох хууль-дүрэм, тушаал, заавар, журам, зэргийг санаатай зөрчиж бусдад хор хохирол учруулсан байвал тэрхүү үйлдэл-үйл ажиллагаа нь нийгэмд аюултай гэмт хэрэгт тооцогдоно;

⁵ Саруханян, А. Р. Преступления против порядка управления. (Ставрополь, 2003, 122-р тал)

3. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцогдох бодит үндэслэл, хэр хэмжээний дотор болсон байвал уг үйлдлийг гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй гэмт хэрэгт тооцох нь зохистой. Гэхдээ тэгэж тооцогдох бодит үндэслэлүүдийг нарийвчлан тогтоох нь нэн ойлгомжтой юм;
4. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны улмаас бодит хор хохирол учруулсан асуудлыг шийдвэрлэхдээ түүнийг онцгойлон авч үзэхгүйгээр холбогдох хуульд тогтоосон ерөнхий үндэслэлүүдийн дагуу шийдвэрлэх шаардлагатай;
5. Хэрвээ хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь гэмт хэргийг үгүйсгэж байгаа бусад нөхцөл байдлуудын (аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал гэх мэт) нэгэн адил зохих үндэслэл хэр хэмжээ, шалгуурын дагуу болсон байвал уг үйлдлийг нь мөн чанарын хувьд эрх ёсны буюу зүй ёсны ажиллагаанд тооцно;
6. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь тодруулбал тэрхүү бодит үйлдэл нь болгоомжгүй байдлаар илэрвэл уг үйлдлийг гэм буруугийн болгоомжгүй хэлбэртэй гэмт хэрэгт тооцно;
7. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь түүнд нөлөөлсөн бодит хүчин зүйл шалтгааны улмаас тухайн тодорхой нөхцөлд түр зуурын шинжтэй байж болох тохиолдол гардаг буюу гарч болзошгүй тул уг асуудлыг шийдвэрлэхдээ бусад нөхцөл байдлуудыг шийдвэрлэдэг ерөнхий үндэслэлийг баримталвал зохистой;
8. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлын хэмжээ нь гол төлөв түүнд нөлөөлсөн гадаад бодит хүчин зүйлээс хамаарах тул хохирлын хэмжээг тухайн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлийг харгалзан тогтоох шаардлагатай мэт санагдна;

Ийнхүү хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь бодит үндэслэл, шалгуур, хэр хэмжээтэй байдаг болох нь нэн тодорхой бөгөөд гагцхүү тэдгээрийг холбогдох хууль-эрх зүйн актад урьдчилан заасны дагуу тал бүрээс нь бүрэн дүүрэн, бодитой тогтоох шаардлагатай юм.